

Батлав.

БХБЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.Байршил	Сүхбаатар дүүрэг 9-р хороо орон сууцны VII хороолол
2.Ажлын цар хүрээ	Барилгын талбайд түр байр /ИТА нарын контор/, шалган нэвтрүүлэх байр, харуулын байр-3ш угсралтын ажил
3. Барилгын ажилд тавигдах ерөнхий шаардлага	<p>Барилгын талбайд түр байр /ИТА нарын контор/, шалган нэвтрүүлэх байр, харуулын байруудын угсралтын ажил</p> <p>Сүхбаатар дүүргийн 9-р хороонд баригдах орон сууцны хорооллын барилга угсралтын ажилд хяналт тавих ИТА-нуудын байрлах албан ажлын зориулалттай /контор/ байрны болон шалган нэвтрүүлэх байр, харуулын байрууд /3ш/-ын угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.</p> <p>Энэхүү тендерт дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p><b>1. Контор:</b> Нийт 244,32 мкв талбай бүхий /албан ажлын өрөөнүүд, хурлын заал, цайны өрөө/ албан ажлын зориулалттай өрөөнүүд байх бөгөөд өвөл зуны аль ч улиралд ашиглах боломжтой түр байр болно. 01/2020-СЦД шифртэй ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>Хүснэгтээр өгсөн ажлын тоо хэмжээг ажлын зурагтай тулган нягталж төсөв тооцоогоо хийнэ үү.</p> <p>Төсөвт металл каркасны үнийг 36,0 сая төгрөгөөр, зураг төсвийн үнэ төгрөгийн төсвийн дүнд тусгана.</p> <p>Энэхүү түр байрны нил суурийг цутгалт хийгдсэн байгаа тул төсөвт тусгахгүй. /Фото зураг хавсаргав хавсралт-1.2/</p> <p>Халаалтын системд хөлдөхгүй шингэн /антифриз/ хэрэглэхээр тооцно.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд өмнө нь хийгдсэн байгаа гадна цэвэр усны шугам хоолойг төв шугамаас /300мм-ийн/ огтолгоо авч холболт хийх, цэвэр, бохир усны холболт хийх зэрэг ажлуудыг хийж дуусган түр байрыг бүхэлд нь ашиглалтад оруулахаар тооцно. /гадна цэвэр усны шугамын байгуулалтын зургийг хавсаргав Хавсралт-1.1/</p> <p>Жич: 2019 онд талбай бэлтгэх ажлын хүрээнд түр байрны суурь цутгалт, гадна цэвэр, бохир усны шугамын угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн боловч түр байрны угсралтын ажилтай уялдан дуусаагүй байгаа болно. Иймд энэхүү тендерийн хүрээнд дутуу байгаа зарим ажлуудыг бүрэн хийж дуусгах шаардлагатай болно. Үүнд: гадна цэвэр усны шугамыг төв шугамаас огтолгоо авч холболт хийгээгүй, ариун цэврийн өрөөнд одоо байгаа шугам хоолой, тоноглолын байрлалыг өөрчлөн зөөх, түр байр баригдсаны дараа гал тогооны болон гар угаах угаагуурын цэвэр бохир</p>

усны холболт хийх зэрэг ажлууд хамаарах тул төсөв тооцоондоо тусгана уу.

**2. Шалган нэвтрүүлэх байр:** Нийт 15.74 мкв талбайтай металл каркас бүхий сендвичэн хана, дээвэр бүхий битүүмжлэл сайтай, дулааны алдагдалгүй байхаар төлөвлөнө.

Өгсөн эскиз /хавсралт-2.1,2.2/ зургийн дагуу хийцийн тооцоог хийж, шийдэл гарган, бүтээц, цахилгааны нарийвчилсан ажлын зургийг боловсруулж, төсөв тооцооны хамт ирүүлнэ.

Гадна хана, дээврийн сендвич хавтангийн зузаан б-150мм-ээс багагүй, /үүнтэй дүйцэхүйц/ , хуванцар рамтай шилэн багц бүхий вакуум цонхтой, бат бөх төмөр хаалгатай, дулааны алдагдалгүй байхаар төлөвлөнө.

Хамар хана нь хөнгөн хийцтэй, угсармал /хуванцар рам бүхий шилэн вакуум хана, хаалга/ байхаар тооцно. Хана шал, тааз нь бүхэлдээ дулаалгатай, өнгөлгөөний материалаар өнгөлж хийнэ.

Цахилгаан панелан радиатор бүхий халаалтын систем, эрчим хүчний хэмнэлттэй лед гэрэлтүүлэг, унтраалга, розетка /5ш-ээс доошгүй/ байхаар төлөвлөнө. Цахилгаан радиаторын утсыг тусад нь монтажлана.

Автомат бүхий цахилгааны самбартай байна.

Хяналтын системийн хувьд гадна байрлах хүчин чадалтай 4ш камер байрлуулан удирдлагын системд холбоно.

**3. Харуулын байр /3ш/:** 2,5м\*2,5м хэмжээтэй 2м-ээс доошгүй өндөртэй металл каркас бүхий сендвичэн хана, дээвэр бүхий битүүмжлэл сайтай, дулааны алдагдалгүй байхаар төлөвлөнө. Газрын түвшингээс 2,5м-ээс багагүй өндөртэй металл каркас бүхий тавцан дээр байрлуулна.

Өгсөн жишиг /хавсралт-3.1, 3.2/ зургийн дагуу хийцийн тооцоог хийж, шийдэл гарган, бүтээц, цахилгааны ажлын нарийвчилсан зургийг боловсруулж, төсөв тооцооны хамт ирүүлнэ.

Гадна хана, дээврийн сендвич хавтангийн зузаан б-150мм-ээс багагүй, /үүнтэй дүйцэхүйц/ , хуванцар рамтай шилэн багц бүхий вакуум цонхтой, бат бөх төмөр хаалгатай, дулааны алдагдалгүй байхаар төлөвлөнө.

Дээрх шалган нэвтрүүлэх байр болон харуулын байрны шийдэл нь ерөнхий жишиг шийдэл бөгөөд нарийвчилсан техникийн шийдэл, ажлын зургийг гаргаж ирүүлнэ. Албан ажил гүйцэтгэхэд дулаахан, тохилог, ая тухтай, угсрах, зөөвөрлөхөд авсаархан, дахин ашиглах боломжтой, дэвшилтэд технологи бүхий үүнээс илүү давуу талтай шийдлийг санал болгон ирүүлж болно.

**4. Барилгын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд**

Шалган нэвтрүүлэх байр болон харуулын байруудын гадна цахилгаан, хяналтын камерын холболтуудыг ажил гүйцэтгэх явцад захиалагчтай хамтран газар дээр нь шийдэл гаргаж холболт хийнэ.

Дээрх ажлуудыг норм дүрэм, стандартын дагуу чанартай сайн хийж гүйцэтгэнэ. БУА-ын технологийг чанд мөрдөнө.

Өртгийг тодорхойлохдоо 2020 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, жишиг тарифийг мөрдсөн байна. Ажил гүйцэтгэхтэй холбогдсон бүх зардлыг /техник хяналтын зардал, магадлашгүй ажил, татвар хураамж, нүүлгэн шилжүүлэх г.м/ үнийн саналд хамруулсан байна. Хэрэв тооцоогүй тохиолдолд захиалагч хариуцахгүй.

Орчин үеийн дэвшилтэд технологи бүхий материалыг өргөн ашиглахаар тусгана. Хэрэглэх материалууд нь шинэ, ашиглагдаагүй, эрүүл ахуйн болон ашиглалтын чанарын шаардлага хангасан байхаар сонгоно.

Материал сонголт, өнгө будгийн шийдлийг ажил гүйцэтгэх явцад захиалагчтай зөвшилцөнө.

Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг төслийн захиалагч болон зохиогчийн /техникийн/ хяналт хийлгэж үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцлийг гүйцэтгэгчийн зүгээс бүрэн хангаж ажиллана.

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Барилгын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтад өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.

Угсралтын ажлын явцад техникийн шийдэлтэй уялдан гарах асуудлыг газар дээр нь захиалагч болон бусад холбогдох хүмүүстэй хамтарч шийдэл гаргаж хэрэгжүүлнэ.

Талбайд барилгын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн захиалагчаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж ажиллана.